

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг дуустал, анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Хамтын аж амьдрал, харилцаа бүхий бие биедээ эерэг ба сөргөөр харилцан үйлдэл, үйлчлэл үзүүлэгч хүмүүсийн бүлгүүдийн цогцыг онолын ямар ойлголтоор илэрхийлдэг вэ? \1 оноо\
A. Нийгэм
B. Иргэншил
C. Улс үндэстэн
D. Нийгмийн дэвшил
E. Соёл
2. Аль нь буруу бодомж вэ? \1 оноо\
A. Гол статус нь тухайн хүний эрхэлж байгаа ажил
B. Олдмол статус нь хүний өөрийнх нь хүчин чармайлтаар тодорхойлогддог
C. Төрөлх статус нь хүний авьяас чадвар, өөрт нь төрөлхөөс заяагдмал статус
D. Хүний яс үндэс, нутаг орон, угсаа гарал нь олдмол статуст хамаарна
E. Хүний нийгэмд эзлэх байр суурь нь эрх, үүрэгтэй нэгдэхээр статус болдог
3. Нийгмийг тайлбарлах “Атомист” онолын хандлага аль нь вэ? \1 оноо\
A. Нийгэм бол хамтын амьдралын цогц илрэл
B. Нийгэм бол байгаль, соёлын харилцан үйлчлэл
C. Нийгэм бол оршин амьдарч буй хувь хүмүүс, тэдгээрийн хоорондын харилцааны цогц
D. Нийгэм бол нягт хэлхээ холбоонд оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо
E. Нийгэм бол амьд организм лугаа өөрөө хөгжигч тогтолцоо
4. Нийгмийн харилцаа гэж юу вэ? \1 оноо\
A. Үндсэн элемент нь хүмүүс, тэдгээрийн харилцаа холбоо болдог бүхэл бүтэн байгууламж
B. Хүний амьдралын асуудлыг шийдвэрлэдэг, тогтвортой дахин давтагддаг, тухайлан хэлбэржсэн харилцаа
C. Хүмүүс бие биедээ нөлөөлж, үйлчилж байдаг үйл явц
D. Үндэстэн, угсаатан, ястнуудын хоорондох бичил харилцаа
E. Эдгээрээс өөр
5. Нийгмийн институтыг үндсэн ба үндсэн бус гэж ангилдаг. Тэгвэл үндсэн бус институт ньюм. \1 оноо\
A. Нийгмийн практик
B. Нийгмийн тогтолцоо
C. Нийгмийн үүрэг
D. Нийгмийн систем
E. Нийгмийн институц
6. А.Тоффлер, Д.Белл, З.Бжезинский нар нийгэм өөрийн урагшлах хөгжлийн явцад гурван үе шатыг дамждаг гэжээ. Тэгвэл аж үйлдвэржсэний дараах үе шатанд үйлдвэрлэлд юу давамгайлдаг хэмээн тодорхойлсон бэ? \1 оноо\
A. Мэдлэг
B. Мэдээлэл
C. Хөдөө аж ахуй
D. Аж үйлдвэр
E. Үйлчилгээ
7. Нийгмийн институтуудын шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсон бол аль нь вэ? \1 оноо\
A. Гэр бүлийн институт - эцэг, эх, хүүхэд - бөгж, зүүлт, гэрээ
B. Эдийн засгийн институт-ажил олгогч, хөлсний ажилчин-мөнгөн тэмдэгтүүд, худалдаа
C. Шашны институт - хамба, гэсгүй - худалдан авагч
D. Боловсролын институт - Багш, шавь - үнэмлэх, диплом, цол
E. Улс төрийн институт - хууль тогтоомж, эрх зүйн субъект - далбаа, хуулийн эмхэтгэл

8. Зээтүү хэрэглэн тариалах үйлдвэрлэл явуулдаг, харин металл анжис ашигладаггүй байсан нийгмийн хэв маягт аль нь тохирох вэ? \1 оноо\
- A. Агнуурын нийгэм
B. Түүвэрлэгчдийн нийгэм
C. Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм
D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
9. “Нийгмийн ноён нуруу, нийгмийн барилга” хэмээх зүйрлэж болох тулгуур ойлголт алинд нь тохирох вэ? \3 оноо\
- A. Нийгмийн үүрэг
B. Нийгэм
C. Нийгмийн институт
D. Нийгмийн систем
E. Нийгмийн практик
10. Далайд гарцтай орон зам тээврийн тохиромжтой нөхцөлд байдаг бөгөөд БНХАУ далайд гарцтай орон тул мөн тийм юм гэхэд танин мэдэхүйн дараах аргуудын алинд илүү түшиглэж вэ? \3 оноо\
- A. Индукци
B. Дедукци
C. Синтез
D. Анализ
E. Аль нь ч биш
11. Орчин үеийн шатанд холбогдох нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан, тодорхой цаг хугацаан дахь иж бүрэн суурь өөрчлөлтүүдийг юу гэж нэрлэх вэ? \1 оноо\
- A. Нийгмийн шинэчлэл
B. Нийгмийн дэвшил
C. Нийгмийн хөдөлгөөн
D. Хувьсгал
E. Хувьсал
12. Хүний олдмол статус ойлголтонд хамаарахыг олно уу? \3 оноо\
- A. Миний эгчийг Цэвээндоржийн Байгалмаа гэдэг
B. Манайх удахгүй Улаанбаатар хотод шилжин сууна
C. Би 15 настай, Буян гэдэг
D. Манай аав удмын дуучид
E. Аль нь ч биш
13. Нэг эхнэр, олон нөхөртэй байх гэрлэлтийн хэлбэр аль нь вэ? \3 оноо\
- A. Полигами
B. Полиандри
C. Полигани
D. Моногами
E. Экзогами
14. “Улс төр бол хэн, юуг, хэзээ, хэрхэн олж авч буй тэмцэл” гэж хэн тодорхойлсон бэ? \1 оноо\
- A. Х. Лассуэл
B. Аристотель
C. Ф.Бро
D. Д.Истон
E. Н.Макиавелли
15. Аль бодомж нь буруу вэ? \1 оноо\
- A. Засаглалын орон зай гэдэг нь тодорхой хэмжээтэй газар нутагт засаглалын үйл ажиллагаа үр ашигтай явагдана гэсэн үг
B. Засаглалын цаг хугацаа нь тухайн засаглалын оршин тогтнох хугацаа
C. Засаглалын нөөц гэдэгт иргэд, нийгмийн хэсэг бүлэг, нийгмийг бүхэлд нь ч тооцож болно
D. Засаглалын эзлэхүүн гэдэг нь хичнээн тооны засаглал хэн нэгний буюу ямар нэгэн байгууллагын гарт төвлөрч байгааг харуулдаг
E. Засаглалын хэмжээ гэдэг нь ямар нэгэн засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээ, хэм хэмжээг тодорхойлох үзүүлэлт
16. Эрх мэдлийн хэлбэрүүдэд өгөгдсөн жишээг зөв харгалзуулна уу? \1 оноо\
1. Албадлагын хүч хэрэглэх
2. Наймаалцах
3. Үүрэг үүсгэх
- A. Жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчих
B. Жолооч замын хөдөлгөөний дүрмээ заавал биелүүлэх
C. Жолооч албан татвар төлж, төр зам засварлах
- A. 1A,2B,3C
B. 1A,2C,3B
C. 1B,2C,3A
D. 1B,2A,3C
E. 1C,2A,3B

17. Махатма Ганди, Адольф Гитлер зэрэг удирдагчид хямрал ба өөрчлөлтийн үед ч бусдыг зоригжуулж дагуулж чадсан хүмүүс. Эдгээр удирдагчдын нэр хүндийн эх үүсвэрийг хэрхэн тодорхойлж болох вэ? \1 оноо\
- A. Уламжлалд суурилсан нэр хүнд
C. Хууль ёсны эх үүсвэртэй нэр хүнд
E. Албан тушаалын нэр хүнд
- B. Харизмат нэр хүнд
D. Эрх мэдлийг нэр хүнд болгосон
18. Эрх мэдлийг багтаамжаар нь ангилсан ангилал аль нь вэ? \1 оноо\
- A. Бага, дунд, өргөн
C. Ардчилсан, ардчилсан бус
E. Гэр бүлийн, цэргийн, намын
- B. Эдийн засгийн, мэдээллийн, албадлагын
D. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
19. Улс төрийн системийн оролт, гаралт нь дараах ойлголтуудын алинаар нь дамжин хоорондоо харилцан шүтэлцэж байдаг вэ? \1 оноо\
- A. Дэмжлэг
D. Эргэх холбоо
- B. Шаардлага
E. Үйлдэл
- C. Шийдвэр
20. Улс төрийн тогтолцоог бүрдүүлэгч байгууллагуудыг тоочихдоо буруу зүйл дурьдсан бол аль нь вэ? \1 оноо\
- A. Төр
C. Улс төрийн нам
- B. Олон нийтийн байгууллага
D. Бүгд зөв
- E. Бүгд буруу
21. Төр бол хүчтэй хүмүүсээс нийгэмд дарангуйллаа тогтоох байгууллага бөгөөд эрх зүй бол хүчтэй нь хүчгүйдээ ашиг сонирхолоо тулган хүлээлгэх арга хэрэгсэл буюу төр хүчирхийлэл, ялалтаар төрж, бэхжиж, хөгждөг гэж үздэг хүчирхийллийн онолын төлөөлөгчид аль нь вэ? \1 оноо\
- A. Цицерон, Г.Гроций, Л.В. Хэллер
C. Е. Дюринг, Л.Гумплович, К.Каутский
E. Платон, Сен-Симон
- B. С.Августин, Фома Аквинский
D. К.А. Виттфогель
22. Сонирхолын бүлэг гэдэг нь: \2 оноо\
- A. Ихэвчлэн улс төрийн нэг үзэл суртлыг баримталдаг иргэдээс бүрддэг олон нийтийн байгууллага
B. Төрөөс өөрсөддөө илүү ашигтай, тохиромжтой шийдвэр гаргуулах нийтлэг ашиг сонирхолын үндсэн дээр нэгдэн, хамтран үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийн нэгдэл
C. Ашгийн төлөөх, өөрийгөө удирдах зарчмаар ажилладаг олон нийтийн байгууллага
D. Засгийн эрх мэдлийг авах эрмэлзэл бүхий хүмүүсийн нэгдэл
E. Төрөөс хараат, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага
23. Засгийн эрхийн төлөө эрмэлзэж, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг тодорхой зохион байгуулалттай улс төрийн байгууллагыг гэнэ. \1 оноо\
- A. Үйлдвэрчний эвлэл
C. Сүм хийд
- B. Төрийн бус байгууллага
D. Нам
- E. Төр
24. Орчин үеийн бүгд найрамдах төрийн үндсэн шалгуур аль нь вэ? \3 оноо\
- A. Засгийн газрыг “хэн байгуулж” байгаагаар нь
B. Эзэн хааны эрхийг хэрхэн хязгаарлаж байгаагаар нь
C. Засгийн газар “хэний” өмнө хариуцлага хүлээж байгаагаар нь
D. А ба С хариулт зөв
E. E. Дээрх бүгд буруу
25. Нийгмийн амьдралын бүх хүрээнд хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг бодитой баталгаажуулах, төр иргэн 2 харилцан хариуцлага хүлээх явдал нь ямар төрийн шинж вэ? \3 оноо\
- A. Ардчилсан бус төрийн шинж
C. Социалист төрийн шинж
E. Эрх зүйт төрийн шинж
- B. Хөрөнгөтний ардчилсан төрийн шинж
D. Аливаа төрийн шинж

26. Сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг сонгуульд ялсанд тооцох арга аль нь вэ? \1 оноо\
- A. Пропорцианаль тогтолцооны арга
B. Мажоритар тогтолцооны арга
C. Хувь тэнцүүлэх тогтолцооны арга
D. Холимог тогтолцооны арга
E. Аль нь ч биш
27. Улс төрийн засаглалын гол шинж нь хүч хэрэглэх бус, нэр хүнд байх ёстой гэж үздэг бөгөөд “Улс төрөөс бусдыг зөвшөөрнө” гэсэн зарчмыг удирдлага болгодог дэглэм аль нь вэ? \2 оноо\
- A. Тоталитар дэглэм
B. Авторитари дэглэм
C. Ардчилсан дэглэм
D. А ба В хариулт зөв
E. Дээрх бүгд зөв
28. Монгол Улсын Үндсэн хуульд эдийн засгийн талаар заасан зөв заалтыг тэмдэглэнэ үү? \1 оноо\
- A. Олон хэвшил бүхий эдийн засагтай байна
B. Зах зээлийн өрсөлдөөн бүхий давамгалсан эдийн засагтай байна
C. Төрийн өмч давамгалсан эдийн засагтай байна
D. Хувийн өмч давамгалсан эдийн засагтай байна
E. Төрийн зохицуулалт бүхий эдийн засагтай байна
29. Нийлүүлэлтийн хуульд нөлөөлөх нь аль вэ? \1 оноо\
- A. Үйлдвэрлэгчдийн тоо нөлөөлөх
B. Тоног төхөөрөмж түүхий эдийн үнэ нөлөөлөх
C. Техник технологийн өөрчлөлт нөлөөлөх
D. Тухайн барааны үнэ нөлөөлөх
E. Бусад барааны үнэ нөлөөлөх
30. Дараах тохиолдлуудын алинд нь бараа, үйлчилгээний *илүүдэл* үүсдэг вэ? \1 оноо\
- A. Эрэлт < нийлүүлэлт
B. Эрэлт > нийлүүлэлт
C. Эрэлт = нийлүүлэлт
D. А ба В хариулт зөв
E. Аль нь биш
31. Наадмаар хөдөөнөөс ирсэн хүн авчирсан хонио зарж чадалгүй гутлаар солиод буцжээ. Энэ ямар төрлийн худалдаа вэ? \2 оноо\
- A. Бэлэн бус мөнгөөр худалдсан
B. Бэлэн мөнгөний худалдаа
C. Бартерийн худалдаа
D. Тэр хүн хонио худалдаж чадаагүй
E. Бүх хариулт буруу
32. Зөв холбоно уу ? \ 2 оноо\
- | | |
|---------------------------------------|---|
| 1. Алдагдсан боломжийн өртөг | A. Юу үйлдвэрлэх, яаж үйлдвэрлэх, хэнд зориулж үйлдвэрлэх тухай асуудал |
| 2. Эдийн засгийн амьдралын гол зөрчил | B. Хомс хязгаарлагдмал байдлын эрхшээлээр боломжтой хувилбаруудаас сонголт хийснээр алдаж байгаа ашигт чанар |
| 3. Эдийн засгийн үндсэн асуудал | C. Хязгаарлагдмал нөөц баялгаар олон янзын хязгааргүй хэрэгцээг хэрхэн, яаж зүй зохистой хангах тухай асуудал |
- A. 1A, 2C, 3B B. 1B, 2A, 3C C. 1B, 2C, 3A D. 1C, 2B, 3A E. 1C, 2A, 3B
33. 1929-1933 оны үеийн дэлхийн эдийн засгийн хямралын шалтгааныг тодорхойлж, зах зээлд төрийн оновчтой зохицуулалт шаардлагатайг онцолсон эдийн засагч хэн бэ? \1 оноо\
- A. А.Маршалл B. А.Смит C. М.Кейнс
D. А.М. Фридман E. К.Маркс
34. Хэвийн инфляцийг тодорхойлно уу? \2 оноо\
- A. Тухайн нөхцөл дэх барааны хомсдол, хүн амын орлогын дутагдал зэргээс болж үүссэн инфляци
B. Инфляцийн хурд нь мөлхөө түвшинд хэвийн явагдаж байвал ил инфляци гэнэ
C. Үнийн өсөлтийг төрөөс зохиомлоор дэмжсэний улмаас үүссэн инфляци
D. Бүх хүмүүст инфляцийн хурд нь илт мэдрэгдэж байвал ил инфляци гэнэ
E. Бүгд буруу

35. Чөлөөт зах зээл дэх “далд гар” нь: \2 оноо\
- A. Илүүдэлтэй барааны үнийг өсгөдөг B. Хомсдолтой барааны үнийг бууруулдаг
C. Үнийн тэнцвэржилтийг бий болгодог D. Үнийн хөөрөгдлийг бий болгодог
E. Бараа бүтээгдэхүүний хомсдолыг бий болгодог
36. Аль нь ажилгүйдлийг бууруулах захиргааны арга замд хамаарах вэ? \2 оноо\
- A. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих
B. Цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
C. Хөдөлмөрийн багтаамж ихтэй жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
D. Импортыг орлуулах бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг дэмжих
E. Мэдээллийн сүлжээ бий болгох, мэргэжил олгох, давтан сургах
37. Өрхийн төсвийн зарлагыг илэрхийлэх жишээнд илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \2 оноо\
- A. Хувцас эдлэл B. Гэрэл цахилгаан C. Хоол хүнс
D. Цалин, хөлс E. Тавилга хэрэгсэл
38. Нийгмийн бүлгүүдийн тэгш бус байдлыг шашны хуулиар тогтоож өгдөг давхраажлын хэв маяг аль нь вэ? \1 оноо\
- A. Каст B. Боолчлол C. Язгуур D. Анги E. Аль нь ч биш
39. Дараах жишээнүүдээс нийгэм дэх шилжих хөдөлгөөний хэлбэрүүдэд үл хамаарахыг олно уу? \2 оноо\
- A. Иргэн Бямбаа бизнес хийхээр Сөүл хот руу явсан
B. Мянгат малчин Дорж, зуднаар бүх малаа алдаж хоосорч ядуурчээ
C. Эмч Оюунбилэг Улаанбаатар хотоос Хэнтий аймаг руу шилжин суурьшсан
D. Малчны хүү Ж.Гүррагчаа Монголын анхны сансрын нисгэгч болсон
E. Буудлагын спортын мастер тамирчин О.Гүндэгмаа хөдөлмөрийн баатар болсон
40. Эрх мэдэл, орлого нь дорвитой өөрчлөгдөхгүйгээр нэг ажлаас нөгөөд шилжихийг гэнэ. \1 оноо\
- A. Байр суурь үл өөрчлөгдөх шилжилт B. Бүтцийн шилжих хөдөлгөөн
C. Нийгмийн шилжих хөдөлгөөн D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
E. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
41. Орчин үед нь давхраажлын дөрөв дэх хэмжигдэхүүн гэсэн бол аль нь вэ? \1 оноо\
- A. Эд баялаг B. Нэр хүнд C. Эрх мэдэл
D. Боловсрол E. С ба D хариулт
42. *Нийгмийн халамж* хэмээх ойлголтонд аль нь хамаарах вэ? \1 оноо\
- A. Төрөөс зайлшгүй туслалцаа дэмжлэг үзүүлэх шаардлагатай хүмүүсийг ивээлдээ авах үйл ажиллагаа
B. Иргэн болон аж ахуй нэгж, байгууллагад зохих журмын дагуу үйлчлэх үйл ажиллагаа
C. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа
D. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа
E. А ба C, D хариулт зөв
43. ХХК-д компанид ажилладаг Төмөр байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас цомхотголд орж, ажилгүй болсон байна. Энэ тохиолдолд Төмөр нь нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу *нийгмийн даатгалын ямар төрлийн сангаас* тэтгэмж авах вэ? \1 оноо\
- A. Тэтгэврийн даатгалын сангаас B. Тэтгэмжийн даатгалын сангаас
C. Ажилгүйдлийн даатгалын сангаас D. Эрүүл мэндийн даатгалын сангаас
E. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас
44. Албан ёсоор тогтоосон ядуурлын босгон дотор амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг аль ойлголт нь илэрхийлэх вэ? \1 оноо\
- A. Ядуурлын босго B. Харьцангуй ядуурал
C. Үнэмлэхүй ядуурал D. Ядуурлын хэмжээ E. Аль нь ч биш

45. Орчин үеийн боолчлолын хэлбэр аль нь вэ? \1 оноо\

- A. Хүний наймаа B. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр
C. Хүчинд автан гэрлэх D. Бэлгийн боолчлол E. Дээрх бүгд

46. Соёл урлаг хэмээх ойлголтуудын харилцааг илэрхийлсэн зөв бодомж аль нь вэ? \1 оноо\

- A. Соёл нь урлагаас өргөн, урлагийг өөртөө багтаана
B. Урлаг нь соёлоос өргөн, соёлыг өөртөө багтаана
C. Энэ хоёр ойлголт эн тэнцүү ойлголт
D. Эдгээр институтуудад огтолцох цэг байхгүй
E. Эдгээрээс өөр

47. Ардын соёлын жишээ аль нь вэ? \1 оноо\

- A. Сонгодог урлаг B. Тоглоомонд донтох C. Хөөмий
D. Шинжлэх ухаан E. Философи

48. Нийгмийн хэм хэмжээг сахиулахын тулд хүмүүсийг сайшаах болон шийтгэх хэрэгслүүдийг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\

- A. Санкц B. Хууль C. Хариуцлага
D. Хяналт E. Дүрэм журам

49. Соёлуудын харилцан тархалт дэлгэрэлтийг ямар үзэгдэл гэдэг вэ? \1 оноо\

- A. Соёлын хадгалагдах үзэгдэл B. Соёлын харилцах үзэгдэл
C. Соёлын диффузи үзэгдэл D. Соёлын дамжих үзэгдэл E. А ба В зөв

50. Ардын билэг авьяастнууд бүтээдэг соёл аль нь вэ? \1 оноо\

- A. Үндэсний соёл B. Ардын соёл C. Дагуул соёл
D. Элит соёл E. Нийтийн соёл

51. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? \3 оноо\

1. Бэлгэ тэмдэг	A. Оюуны соёлын гол цөм, хамгийн түргэн хувьсаж хөгждөг хэсэг
2. Хэл	B. Соёлын амин сүнс
3. Мэдлэг	C. Утгыг харилцан ойлголцох нэг хэрэгсэл

- A. 1A, 2B, 3C B. 1C, 2A, 3B C. 1C, 2B, 3A D. 1B, 2C, 3A E. 1B, 2A, 3C

52. Аль нь олон улсын улс төрийн харилцааны хэлбэрийг илэрхийлж байна вэ? \1 оноо\

- A. Бараа үйлчилгээг улс үндэстэн, бүс нутгийн хэлээр дамжуулан солилцох
B. Улс орнуудын хооронд гэрээ хэлэлцээр байгуулах, элч төлөөлөгч солилцох
C. Түүх соёлын үнэт зүйлсээ гадаад орнуудад таниулах, сурталчлах
D. Гадаад орнуудад Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулах
E. Өнөөгийн байдлаар Монгол улсад оруулсан, хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ БНХАУ нь хөрөнгө оруулагч бусад орнуудыг тэргүүлж байна

53. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний үндсэн хэрэгцээг хангахад туслах, хүүхдийн бүхий л чадавх бололцоог хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага аль нь вэ? \1 оноо\

- A. ЮНИДО B. ЮНЕСКО C. ЮНИСЕФ D. ОУВС E. ДЭМБ

54. “Дэлхийн Зөн” олон улсын харилцааны аль субъектэд хамаарах вэ? \2 оноо\

- A. Олон улсын байгууллага B. Үндэстэн дамнасан байгууллага
C. Ард түмэн D. Төр E. Алинд нь ч хамаарахгүй

55. Монгол улс хэдэн онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон бэ? \1 оноо\

- A. 1946 B. 1960 C. 1961 D. 1962 E. 1990

56. Шашин шүтэх, эс шүтэх нь хүний хамаарна. \1 оноо\

- A. Иргэний эрхэд B. Нийгмийн эрхэд C. Эдийн засгийн эрхэд
D. Улс төрийн эрхэд E. Оюуны эрхэд

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Иргэншил	1	Тодорхой хил хязгаар бүхий нутаг дэвсгэрт хуулийн ерөнхий тогтолцоо, үндэсний ялгарал бүхий хүмүүсийн нэгдэл
b	Нийгэм	2	Хүний салшгүй гол шинжүүдээр ижилссэн, тогтвортой холбоо бүхий, бие даасан байдлаар оршдог, тодорхой субъект бүлэг хүмүүс
c	Нийгмийн нийтлэг	3	Нийгэм ба соёлын хөгжлийн шат, тодорхой түвшин, өвөрмөц шинжийн цогц
d	Нийгмийн дэвшил	4	Нийгэм хийгээд хүний амьдралын нөхцөл, чанар дээшлэх, амьдрах арга ухаан төгөлдөрших зэрэг томоохон хэмжээний зэрэг үр дагавруудын үр дүн
e	Соёл	5	Нийгэм хүмүүсийн зан үйлийг албан ба албан бусаар зохицуулагч хэм хэмжээ, уламжлал, зан заншил, ёс суртахуун

2.2 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Ардчиллын тухай сонгодог онол, үзэл санаа (дэглэм)	1	Улс төрийн амьдралд шийдвэр гаргахад бүх хүнийг оролцуулах боломжгүй боловч ардчиллын зарчмуудыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой
b	Ардчиллын тухай элитийн онол (дэглэм)	2	Иргэд нь сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтнаар дамжуулалгүй нийгмийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд өөрсдөө биеэр оролцдог хэлбэр
c	Олон ургалч ардчиллын онол (дэглэм)	3	Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй байна
d	Шууд ардчилал (хэлбэр)	4	Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах, ард түмний тусын тулд хөтөлбөрөө биелүүлэх үүрэг бүхий албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх
e	Төлөөллийн ардчилал (хэлбэр)	5	Нийгэм бол засаглалыг гартаа барьж буй удирдагч цөөнх, үлдсэн нь удирдуулагч олонхи гэсэн хоёр хэсэгт хуваагддаг бөгөөд төрийн бодлогыг удирдагч цөөнх нь тодорхойлдог

2.3 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Д.Рикардо	1	Тодорхой нэрийн бүтээгдэхүүн үйлчилгээний импортлох тоо хэмжээнд тавих хязгаарлалт
b	Тарифын хязгаарлалт	2	Гаалийн тарифыг нэмэгдүүлэх
c	Квот	3	Чөлөөт худалдааны онолыг үндэслэгч
d	Демпингийн арилжаа	4	Бараа үйлчилгээг өөрийн оронд борлуулснаас гадаадад борлуулсан нь хямд байхаар бодож экспортын нөхвөр олгох
e	Гадаад худалдаа	5	Экспорт, импорт

2.4 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Овог	1	Тодорхой нутаг дэвсгэрт амьдарч байгаа нэг үндэстнүүдийн угсаатны шинж чанарууд
b	Аймаг	2	Тодорхой газар нутгийн хүрээнд түүхэн ёсоор тогтсон соёл, сэтгэл зүйн ерөнхий шинж онцлогийг хадгалсан, урт удаан хугацааны холбоотой том бүлэг хүмүүсийн тогтвортой цогц
c	Ястан	3	Овгийг бодвол хэдэн зуугаас хэдэн мянган хүмүүс, хэд хэдэн овгоос бүрдсэн хүмүүсийн үлэмж томоохон нийтлэг
d	Үндэстэн	4	Гарал үүслийн нийтлэг, нэг хэл яриа, нийтлэг хэл заншил, шүтлэг, соёл аж байдлын шинжийг эзэмшсэн, цусан төрлийн холбоо бүхий бүлэг
e	Угсаатан	5	Нийтлэг хэл, сэтгэл зүйн онцлог, заншил, зан төрх уламжлалаар бэхжсэн, аж төрөх ёс, соёлын онцлогоор холбогдсон, нэг газар нутагт амьдарч буй хүмүүсийн нийтлэг

